

**МУИС-ийн Ахмад эрдэмтэн багш, ажилтны анхдугаар
чуулган уулзалтаас гаргасан
„Санамж бичиг”**

МУИС-ийн Ахмад багш, Ажилтны Нэгдсэн Холбоо, МУИС-ийн захиргаа хамтран зохион байгуулсан Ахмад эрдэмтэн багш ажилтны анхдугаар чуулган уулзалт ажил хэрэгч, зохион байгуулалтын өндөр хэмжээнд болсныг сайшаан тэмдэглэж байна. Чуулган уулзалт дээр эрдэмтэн багш, ажилтны хэлсэн үг, гаргасан санал, хүсэлтийг нэгтгэн, нийт бүрэлдэхүүн сургуулиудын удирдлага, багш, ажилтан ажилчид, оюутан суралцагчдадаа хандаж, “Санамж бичиг” гаргав.

1. МУИС-ийн багш, ажилтан ажилчид, оюутан суралцагчдад нь МУИС-ийнхаа нэр хүндийг өндөрт өргөж, суралцах хариуцлагаа өндөржүүлж ёс зүйн өндөр соёлтой, хийж бүтээх эрмэлзэлтэй, ахмад болон залуу үе, бие биеэ хайрлан хүндэтгэж, эрдмийн эрх чөлөөгөө дээдлэн, МУИС-даа ажиллаж, хөдөлмөрлөж, суралцах нь нэр төрийн хэрэг хэмээн үзэхийг нийт хамт олонд уриалж байна.

2. Залуу эрдэмтэн багш нар сургуулийнхаа түүхэн уламжлалыг бахархан хадгалж, ахмад үеийнхээ сургамж сургаал, туршлага ололтыг үргэлжлүүлэн, эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа идэвхи зүтгэлтэй хийж, дэлхийн нэр хүндтэй сургуулийн жишигт МУИС-аа хүргэх хариуцлагаа ухамсарлан сургалт, эрдэм шинжилгээний ажлаа эрчимжүүлэн, аливаа хүнд суртал, улс төрөөс ангид, байж, шинжлэх ухаанч, шинэлэг үзэл бодол, дадлага, туршлага арга барил эзэмшихийг эрхэм зорилго болгох хэрэгтэйг сануулж байна.

3. Оюутан суралцагсад нь сурах арга барилд шамдан суралцаж, МУИС-ийнхаа нэр төрийг өндөрт өргөж, хичээл зүтгэл гарган суралцахыг эрхэмлэн, зөв үзэл бодолтой, төлөвшиж, ахмад үеэ хүндэтгэн хайрлаж, ахмад үеийнхээ хийж бүтээснийг үргэлжлүүлэн өвлөж, багш шавийн холбоог ямагт эрхэмлэн хичээнгүйлэн суралцахыг эн тэргүүний зорилгоо болгохыг зөвлөж байна.

4. МУИС-ийн залуу эрдэмтэн багш нар, судалгаа шинжилгээний ажлаа эрчимжүүлж, сургалт судалгааны төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ ахмад эрдэмтэдийн нөөц бололцоог ашиглан хамтран ажиллах, тэднээс суралцах, туршлагыг нь дэлгэрүүлэх, харилцан санал солилцох, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, заах арга барилыг эзэмших, сургалт семинар хамтран явуулах чиглэлээр бүрэлдэхүүн сургуулиуд, төлөвлөгөөтэй ажиллаж, уг ажилдаа ахмад эрдэмтдийг татан оролцуулах боломжийг судлан хэрэгжүүлбэл үр дүнтэй гэдэгт итгэж байна.

5. МУИС-ийн нэр хүндийг өндөрт өргөж яваа ахмад, эрдэмтэн багш нарыг оюутан сурагч залуу багш нартай хамтран ажиллах, мэдлэг чадварыг нь бүрэн дүүрэн ашиглах талаар сургуулийн захиргаанаас цаашид онцгойлон анхаарч, ажиллахыг санал болгож байна.

6. МУИС-ийн ажилтан, албан хаагчид бүр үүрэг хариуцлагаа ухамсарлан цаг ашиглалтын болон харилцааны доголдол, аливаа хүнд суртал гаргахгүй, ажиллаж шуурхай үйлчилгээг дэлгэрүүлэхэд анхаарах хэрэгтэйг сануулж байна.

7. МУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээний ажил, ямагт олон жилийн судалгаан дээр суурилж, дэлхийн сургуулиудын жишигт хүргэхэд мэдлэг чадвар, туршлага, тэтгэвэрт гардаггүйг анхааран үзэж, туршлагатай, мэдлэг чадвартай, ахмад багш нарынхаа нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглаж байж амжилтад хүрэхийг ахмад үеийнхэн нь онцлон тэмдэглэж байна.

8. МУИС-д ажиллаж, хөдөлмөрлөж, суралцаж буй хэн бүхэн ёс зүйн өндөр соёлтой, мэргэжлийн болон сургуулийнхаа нэр төрийг, ариун байлгахад онцгойлон анхаарч, өөрсдийнхөө өмнө тулгарч буй үүрэг, хариуцлага, зорилгоо үнэнч шудрагаар биелүүлэхийг уриалж байна.

МУИС-ийн Ахмад эрдэмтэн багш, ажилтны анхдугаар чуулган,
уулзалтад оролцогсод

2018.03.26.



Улаанбаатар хот